

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

ЗӨСҮТ-ийн Захирал



Н.ЦОГБАДРАХ

БАТЛАВ.

НИЙЛҮҮЛЭГЧ:

МОНВЕТМЕД ХХК-ийн захирал



С.ДЭЛГЭРСАЙХАН

ТЭЖЭЭЛТ ОРЧИН, ХИМИЙН БОДИС, УРВАЛЖ
НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

№ 2016/lab/01.02

2016 оны 04 дүээр сарын 06 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас Зоонозын Өвчин Судлалын Үндэсний Төв (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Монветмед ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2015 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2 Захиалагч нь Оношлуур, тэжээлт орчин, урвалж, химийн бодис худалдан авах 2016/lab/01 тоот тендер шалгаруулалт багц 2 “Тэжээлт орчин, химийн бодис, урвалж”-ийг (цаашид “бараа” гэх) 96,889,000.00 (Ерэн зургаан сая найман зуун наян есөн мянган) төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв.
- 1.3 Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хоёр. Гэрээний бүрдэл

- 2 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 2.1.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 2.1.2 Бусад шаардлагатай баримт бичиг;
 - 2.1.3 Тендер ба үнийн хуваарь;

- 2.1.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 2.1.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 2.1.6 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 2.1.7 Санхүүжилтийн хуваарь.
- 2.2 Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.
- 2.3 Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

Гурав. Нийлүүлэгчийн эрх үүрэг

- 3.1 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог гарсан тохиолдолд арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
- 3.2 Нийлүүлэгч нь бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу захиалагчид нийлүүлнэ.

Дөрөв. Захиалагчийн эрх үүрэг

- 4.1 Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 4.2 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.
- 4.3 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Тав. Гэрээний үнэ, төлбөр хийх нөхцөл

- 5.1 Захиалагч нь гэрээний үнийн дүнгийн 30%-ийг буюу 29,066,700.00 (Хорин есөн сая жаран зургаан мянга долоон зуун) төгрөгийг гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор багтаан нийлүүлэгчид нэхэмжлэлийг үндэслэн шилжүүлнэ.
- 5.2 Захиалагч нь бараа нийлүүлэлтийн 96,889,000.00 (Ерэн зургаан сая найман зуун наян есөн мянган) төгрөгийг улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- 5.3 Гэрээний бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу барааг хүлээлгэн өгснөөс хойш 15 хоногийн дотор захиалагч нь нийлүүлсэн тухайн барааны үлдэгдэл үнийн дүн болох 67,822,300.00 (Жаран долоон сая найман зуун хорин хоёр мянга гурван зуун) төгрөгийг нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ.
- 5.4 Гэрээний үнийн дүнг төгрөгөөр тооцно.

Зургаа. Бараа нийлүүлэх хугацаа

- 6.1 Нийлүүлэгч нь хавсралтанд дурдсан барааг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 45 хоногийн дотор нийлүүлж хүлээлгэн өгнө.

6.2 Энэхүү гэрээний 5.1-д зааснаар урьдчилгаа төлбөрийг Захиалагч хугацаанд нь шилжүүлээгүй тохиолдолд шилжүүлсэн өдрөөс эхлэн 6.1 заалт дахь хугацаа өөрчлөгдөнө.

Долоо. Гэрээний хариуцлага

7.1 Нийлүүлэгч нь бараа бүтээгдэхүүнийг энэхүү гэрээний 6.2-д заасан хугацаанаас хоцорч нийлүүлсэн тохиолдолд хоцорсон хоног тутамд нийлүүлж амжаагүй барааны үнийн дүнгийн 0,2%-тай тэнцэх торгуулийг ногдуулан Захиалагчид төлөх үүрэг хүлээнэ.

7.2 Захиалагч нь Нийлүүлэгчийн нийлүүлсэн барааны төлбөрийг 5,3-д заасан хугацаанаас хоцорч, шилжүүлээгүй тохиолдолд хэтэрсэн хоног тутамд төлөөгүй үнийн дүнгийн 0,2 %-тай тэнцэх алдангийг Нийлүүлэгч талд төлөх үүрэг хүлээнэ.

7.3 Нийлүүлэгч нь бараа бүтээгдэхүүнийг Захиалагчид хүлээлгэн өгөхдөө бараа хүлээлгэн өгөх акт үйлдэж, Захиалагч нь хүлээн авснаа баталгаажуулна.

Найм. Бусад зүйл

8.1 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, тус бүр нэг хувь авч үлдэнэ.

8.2 Энэхүү гэрээ нь талууд эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөрт тооцно.

8.3 Гэрээг хэрэгжүүлэх явцад үүссэн альваа маргаантай асуудлыг талууд харилцан зөвшилцөж шийлдвэрлэхийг урьтал болгох ба хэрэв тохиролцож чадахгүйд хүрвэл Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Чанар хяналт үнэлгээ дотоод
аудитын албаны дарга

..... / Э.Тунгалаг /

Захиалагч: ЗӨСҮТ

Улаанбаатар хот, СХД, 20-р хороо,

Төрийн сан банк данс: 900020021

РД: 9092005

Утас: 70282859

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Монветмед” ХХК-ийн
борлуулалтын менежер

..... /С.Дэлгэрцэцэг/

Улаанбаатар хот, БГДүүрэг
Жамсранжавийн гудамж 40-
99 тоот

Хас банк данс: 5000118181

РД: 2829584

Утас: 99119139, 99117852

Хянасан: Хуулийн зөвлөх *Б.Ариухантөмөр* Б.Ариухантөмөр